



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/115

Төгөл

**Цэрэг татлагын комисс байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2024 оны А/105 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны цэрэг татлагын комисс байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Дарга: М.Батцогт (Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Г.Нямтулга (Хууль, эрх зүйн мэргэжилтэний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Б.Нарангарвуу (Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

С.Доржпагам (ЕБС, насан туршийн боловсролын багш)

Б.Баярхүү (Шивлэг 1-р багийн Засаг дарга)

Д.Пүрэвдаваа (Тоом 2-р багийн Засаг дарга)

Х.Даваа (Мунгараг 3-р багийн Засаг дарга)

С.Мягмардорж (Соёо 4-р багийн Засаг дарга)

Т.Амарсайхан (Төгөл 5-р багийн Засаг дарга)

Л.Баттогтох (Гун 6-р багийн Засаг дарга)


П.Мягмарсүрэн (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Г.Бямбахишиг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

3. Цэрэг татлагын ажлыг ард иргэдэд зарлан мэдэгдэх хуудсаар мэдээллийг тарааж зохион байгуулалттай ажиллах ба цэргийн насны залуучуудад чиглэсэн тодорхой арга хэмжээ зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Отгонбаатар)-д даалгасугай.

ДАРГА  Н.БАТБАЯР



9072284 6715113094